



ГО ВЬСУМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар Б/35

Баянтал сум

М.Бодьгэрэлийг үргэлжлүүлэн
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 136 дугаар зүйлийн 136.1, 136.2, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүүхэд асрах чөлөөтэй байсан Мөнхбатын Бодьгэрэл нь ажилдаа эргэн орох хүсэлтээ гаргасан тул түүнийг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтнээр үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2.М.Бодьгэрлийн ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу хүлээлцэхийг комиссст үүрэг болгосугай.

Комиссын дарга: Л.Отгонпүрэв (Санхүү албаны дарга)


Гишүүд: Н.Сарантуяа (Аж ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга: М.Ичинхорлоо (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

3.М.Бодьгэрэлд хүүхэд хөхүүлж асрах цагт нь зориулж 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 2022 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийг хүртэлх хугацаан дахь ажлын өдрүүдэд өдөр бүр 2 цагийн завсарлага олгосугай.

4.М.Бодьгэрэлд олгох хүүхэд хөхүүлж, асрах завсарлагааны цагийг ажилласан цагт оруулан тооцож, цалинг бодож олгохыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуяа)-д зөвшөөрсүгэй.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Б/35 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  В.ГАНТУЯА



МОҮСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАI СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

0002 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 6/06

Баянтал сум

Г. М.Бодьгэрэлд худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтний
ажлыг хавсруулан ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулалт олгох журам”-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Засаг даргын Тамгын газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтний ажлыг Мөнхбатын Бодьгэрэлд 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн хавсруулан ажиллуулсугай.

2. М.Бодьгэрлийн ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга:

Л.Отгонпүрэв (Санхүү албаны дарга)

Гишүүд:

Н.Сарантuya (Аж ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга:

М.Ичинхорлоо (Архив, бичиг хэргийн
эрхлэгч)

3. М.Бодьгэрэлд худалдан авах ажиллагаа хариуцсан ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 2022 оны 02 дүгээр сар 08-ны өдрөөс эхлэн үндсэн цалингийн 40 хувиар тооцон сар бүр бодож олгохыг нягтлан бодогч (Х.Ариунгуяа)-д зөвшөөрсүгэй.

4. М.Бодьгэрэлд ажилдаа хариуцлагатай хандаж, хууль тогтоомжийг чанд сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөж, хөдөлмөрийн гэрзэгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА
V.ГАНТУЯА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 3/07

Баянтал сум

С.Мөнгөнтамирыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 79 дүгээр зүйлийн 79.1, 110 дугаар зүйлийн 110.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтэн Сүрэнхорлоогийн Мөнгөнтамир нь 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөх хүсэлтээ гаргасан тул 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.С.Мөнгөнтамирын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу ажил хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга:

Л.Отгонпүрэв (Санхүү албаны дарга)

Гишүүд:

Н.Сарантуяа (Аж ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга:

М.Ичинхорлоо (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

3.С.Мөнгөнтамиртай холбогдох тооцоог хийж, ажил амралтын мөнгийг бодож олгохыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуга)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА
С.ГАНТУЯА



ГӨВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 6/08

Баянтал сум

Л.Отгонпүрэвт нэг удаагийн тэтгэмж
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын санхүү албаны дарга ажилтай Л.Отгонпүрэвийн төрсөн хүү Э.Дөлгөөндалай нь хөгжлийн бэрхшээлтэй сар бүр өндөр үнэ бүхий эм, эмчилгээ хийлгэдэг тул “Бэйгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

2.Нэг удаагийн тэтгэмжийг Засаг даргын Тамгын газрын тэтгэмж урамшуулалын зардлаас гаргаж олгохыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА В.ГАНТУЯА



ГОӨБСҮМБЭР АЙМАГ
БАЯНТУЛ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 5/09


Баянтал сум

Н.Сарантуяад нэг удаагийн тэтгэмж
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн нярав ажилтай Н.Сарантуяагийн төрсөн эмээ хүндээр өвчилж, өртөг өндөр эм, эмчилгээ авдаг байдлыг нь харгалзан үзэж 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

2. Нэг удаагийн тэтгэмжийг Засаг даргын Тамгын газрын тэтгэмж урамшуулалын зардлаас гаргаж олгохыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгүй)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

В.ГАНТУЯА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 6/10


Баянтал сум

Э.Буяントогхон нэг удаагийн тэтгэмж
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгууллагын хөдөлмөрийн Дотоод журмын 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн ажилтай Э.Буяントогтохын төрсөн ээж хүндээр өвчилж, өртөг өндөр эм, эмчилгээ авдаг байдлыг нь харгалзан үзэж 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

2.Нэг удаагийн тэтгэмжийг Засаг даргын Тамгын газрын тэтгэмж урамшуулалын зардлаас гаргаж олгохыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

V.ГАНТУЯА